МЭДЭЭ · 2020 оны 7-р сарын 10

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН БАЯР НААДМЫН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Мэдүүлэг

Монгол Улсад тулгар төр үүсэн байгуулагдсаны 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэндчилгээг Прокурорын байгууллагын нийт прокурор, ажилтан, үе үеийн ахмадууд Та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсч байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн баяр тохиож байгаа нь энэ жилийн баяр наадмын онцлог бахархалт үйл явдал болж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Бид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх гэгээн мөртэй, нэр төртэй үүргээ амжилттай гүйцэтгэж, хийж бүтээсэн ажил үйлс, ахиц дэвшил гаргасан өрнүүн амжилтаар үндэснийхээ их баяр наадмыг угтаж байна.

Монгол төрийн хүндэтгэлтэй, амаргүй албыг нэр төртэй, чин шударгаар хашиж, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн, ололт амжилтаа бататгахын төлөө цаг ямагт тэмүүлж байдаг золбоо төгөлдөр прокурор, ажилтан та бүхэн нар асгарч, хур тэгширсэн Монгол наадмаа цог жавхлан, од хийморио чимж, дэнж хотойтол сайхан наадаарай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

Б.ЖАРГАЛСАЙХАН

2020 оны 07 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3199